

Д.Цоодолын хүүрнэл зохиолын туурвил зүйн зарим онцлог

Батмөнхийн МӨНХ-ЭРДЭНЭ*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Утга зохиол судлалын салбарын ЭШДА

Товч агуулга: Тус өгүүлэлд Монгол Улсын төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Цоодолын хүүрнэл зохиолын онцлогийг авч үзжээ. Монгол ахуй, түүний сайхныг сэрж мэдэрсэн уран зураглал, уран санаа, гоо сайхны нээлтэд хүргэсэн дүрслэл, хүн байгалийн шүтэлцээт хүйн холбоо, түүнээ хүний сэтгэлийн олон өнгө аясад нээн үзүүлэхэд чиглэсэн олон зохиол бүтээлийг Д.Цоодол бичжээ. Тэр дундаа монголын орчин үеийн уран зохиолын санд цөөнгүй дууль бичиж өргөсөн гавьяатай билээ. Эл өгүүлэлд Д.Цоодолын хүүрнэл зохиолын туурвил зүйн бусдаас ялгарах онцлог шинж, ур чадварыг тодруулахыг зорьсон байна. Түүнчлэн Д.Цоодолын бүтээл амилах орчны тухай өгүүлж, хүүрнэх арга барилынх нь тухай бичсэн байна.

Түлхүүр үг: Д.Цоодол, туурвил зүй, хүүрнэл зохиол

Монгол Улсын төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Цоодол нь өөрийн гэсэн туурвил зүйн арга барил, өвийг бүтээсэн монголын орчин үеийн уран зохиолын томоохон төлөөлөгч билээ. Тэр бээр утга зохиолын яруу найраг, хүүрнэл зохиол, орчуулга, нийтлэл, эсээ зэрэг бараг бүхий л төрөл зүйлээр жигд ажиллаж томоохон өвийг бүтээсэн уран бүтээлч юм. Түүний уран зохиолын олон талт бүтээл туурвилаас “Харамчийнхан”, “Тэнэг”, “Миний муу сайн найз нар”, “Хуучин дэр модны дууль” тэргүүт олон шүлэг, дууль нь Монголын ард түмний зүрх сэтгэлд хоногшсон нандин бүтээл болсны дээр иргэний утга уянгын яруу найргийн гарамгай сайн жишээ болсон, уран сайхны туурвил зүйн сэтгэлгээний үнэт өв болсон бүтээл билээ. Тэр бээр монгол яруу найргийн дотоод зүйлийн хөгжилд, ялангуяа орчин үеийн монгол дуулийн төрлийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд үнэт хувь нэмэр оруулсан. Түүний туурвил зүйн сэтгэлгээний гүнзгийрэл далайц, уран сайхны шинэчлэл хийсэн арга барил, бодрол бясалгал, гүн ухааных нь үзэл баримтлал, улмаар монголын

* © Б.Мөнх-Эрдэнэ 2024
e-mail: munkherdene_b@mas.ac.mn

орчин үеийн уран зохиолын хөгжилд оруулсан хувь нэмрийг тодруулах нь зүй ёсны хэрэг юм. Д.Цоодол бол яруу найрагч, зохиолч төдийгүй сэтгүүлч, дуун хөрвүүлэгч бөгөөд зөвхөн яруу найрагт ч биш хүүрнэл зохиолын төрөлд ч цөөнгүй өв үлдээсэн байна.

Түүний уран бүтээлийн сэдэв олон өнгө аястай. Иргэний, эх орны, гүн ухаарлын, бодрол бясалгалын хүүрнэлийн, сургаалын, хайр сэтгэлийн, элбэрэл энэрлийн, егөөдлийн гээд амьдралын хөөр баясал, дурсан санах, уяран хайрлах, уулзан жаргах, уйлан дуулах бүхий л өнгө аяс тэр чигтээ багтжээ гэж болохоор байна. Энэхүү олон өнгө аяс нь түүний билгийн мэлмий амьдралыг нээж олж харсан уран санаа, амьдралыг хайрласан дуулал, орчлонгийн мөн чанарыг таньж өгүүлсэн санаа, санаагаа урласан гэгээн яруу тансаг дүр дүрслэл тэр бүхэн байдаг. Д.Цоодолын уран бүтээлүүдэд монгол хүний мөн чанар, амьдрал ахуй, нийгэм, сэтгэхүйн онцлог, ертөнцийг үзэх үзэл төсөөлөл, ёс суртахуун, хайр дурлал, өрөвч нинжин сэтгэл, хүнлэг чанар, оршихуйн мөн чанар зэрэг монголчуудын төдийгүй хүн төрөлхтний мөнхийн үнэт зүйлс хадгалагдаж байдаг.

Д.Цоодол нь яруу найраг, хүүрнэл зохиол, орчуулга, нийтлэл, эсээ зэрэг уран зохиолын бараг бүхий л төрлөөр зүйлээр жигд бичиж томоохон өвийг бүтээсэн уран бүтээлч билээ. Түүний уран зохиолын олон талт бүтээл туурвилаас бид энэ удаад хүүрнэл зохиолынх нь туурвил зүйн онцлогийг судлахыг хичээлээ.

Д.Цоодолын хүүрнэл зохиолыг судлан шинжилсэн нь

Түүний зохиол бүтээлийн уран сайхан, үнэ цэний талаар дотоод гадаадын судлаач, шүүмжлэгчид анхаарлаа хандуулж, өөр өөрийнхөөрөө судлан шинжилсээр ирсэн байна. Чингэхдээ судлаачид голчлон түүний яруу найрагт анхааран судалгаа хийсэн байх бөгөөд түүний хүүрнэл зохиол, орчуулга, сэтгүүл зүйн бүтээлд нь үнэлэлт дүгнэлт өгсөн зүйлс тун ховор байна. Хүүрнэл зохиолынх нь тухайд харин зохиолч, орчуулагчид өгүүлсэн зүйлс цөөн боловч байна. Тухайлбал,

Зохиолч С.Пүрэв түүний зохиолын дүр бүхэн нь амьдралаас эхтэй, өөр өөрийн ааш араншин, хувь заяатай амьд хүмүүс байдгийг олон баримтаар өгүүлээд “Монголоороо байж, тэр чигээрээ өтөлж, Монголоороо үхнэ” гэсэн нэг үг байх. Цоодол найрагчид энэ үг ягштал таарна. Эх орон минь энэ тэрээ хэмээн цээжээ хоосон дэлдэж давхиад байхгүй, мал дагаж халуунд нь халан, хүйтэнд нь хөрж явдаг өнөөх “Хөдсөнд боодолтой” хэдийнхээ төлөө амь тавин, талынхаа энгээр дуулж, уулынхаа өндрөөр сэтгэлээ цэцэлж явдаг Монгол зоноо дуулах нь түүнд бурхнаас буулгасан зарлиг мэт болой. Тиймээс тэр бээр хүн ардаа дүр төрх, аж амьдрал, дотоод баян сэтгэлтэй нь төгс туурвидаг зохиолч мөн болох нь дээрх номуудаас илхэн харагддаг юм. “Нулимс холоос харагдахгүй”-г уншаад үзэхнээ ч тийм л байна. Уншихад урамтай, урам баяр төрүүлэх нүнжигтэй

байна” гээд “Францын Ги Де Мопассан, Финляндын Марти Ларни, суут Расул Гамзатов, Омар Хайям, Оросын Константин Паустовский, Андрей Платонов, Японы Акутагава Рюнэско нарын номуудыг төрөлх хэлнээ буулгаж, дэлхийн уран зохиолын сан хөмрөгөөс бишгүйг зөөхийлсөн нь түүний хүүрнэл зохиолд хөл тавихад аль аль талаараа дэм болсон буй за” гээд “Их талын агь үнэртэж, салхи сэвэлзэн, хүмүүний цовоо дуу сонсогдсон амьд бүтээлүүдээс энэ ном (“Нулимс холоос харагдахгүй”) цогцолжээ” (2013: 3-4) хэмээсэн байна.

Түүнчлэн зохиолч П.Пүрэвсүрэн “... Д.Цоодол цаанаасаа таарсан юм шиг сүүлийн олон жилд “Ардын эрх”, “Өнөөдөр” гээд монголын өдөр тутмын том сонинуудад ажиллаж, хөдөө томилолтоор олон удаа явж, зах зээлд орсон малчны амьдрал ахуйг үзэж, өөрийнхөө хамгийн элгэн хайртай газар орон, хүмүүсийн өнөө ирээдүйн тухай бодож эргэцүүлж, тэдний тухай шүлэглэж, сурвалжилга, тэмдэглэл, найруулал, хөрөг байнга бичсэн зэрэг нь өдгөө үргэлжилсэн үгээр туурвих амаргүй ажилд нь аятай сайнаар нөлөөлсөн байх гэж эл ном (“Хөөө”) -ыг уншаад би бодож байна. Тууж, өгүүллэг, эсээгээр цогцлоосон энэ номын баатруудын амьдрал ахуй, ааш зан, авир төрх, зовлон жаргал яг л манай хөдөөнийхний өнгөрсөн болоод өнөөгийн тодорхой, тодорхой олон хөрөг дүр болжээ. Цоодолын маань энэ номыг төрсөн нутгийнхан нь уншиж гэмээнэ баатруудыг нь андахгүй таньж, энд гарч байгаа тэр тэр чинь манай голын тэр тэр гуай л байна шүү дээ гэж яриа дэлгэн хөхрөлдөнө гэдэгт итгэж байна. Зохиол амьд болсны, дүр бүтсэний шинж бол энэ юм” (2011: 4) гэжээ.

Орчуулагч Ж.Нэргүй “Цоодол абугай шүлгээр хөрөг зураад зогсохгүй, хүүрнэл дурсамжаар гайхалтай сайхан хөргүүд мөн ч олныг бүтээсэн байдаг. Дандаа л гэгээн сайхан өнгө будаг ханхалсан, гэрэлт ариун хүндлэлийн мөрүүдээрээ гийгүүлсэн тийм сайхан “зургууд”. Нинжин сэтгэлээр асарч явдаг хүн л тийм бүтээл туурвидаг юм. Ямар ч хүнийг муулах түм буман шалтаг, шалтгаан олдох, харин тэр хүнийг сайлах ганцхан л чанар байх аваас түүнийг нь олж хараад, цааснаа буулгана гэдэг бол бурхан бүтээснээс юуны ялгаа хэмээн молхи би будангуйрч, мөнөөхөн их нулимсаа асгаруулах дээрээ тулах. Нэг удаа бүр асгаруулж ч орхисон юм. Цоодол гуайнхаа нэг ботийг, одоогоос дөрөв, таван жилийн өмнө дөө, хар өглөөгүүр босоод уншиж байтал нутгийнх нь нэг эр хар хүний тухай дурсамж тааруут, өөрийн эрхгүй муу бурхан аав минь нүднээ тодорч ирээд, тэгэхээр нь хэр баргийн зохиол уншаад тэгж айхтар сэтгэл хөдөлдөггүй муу хөлдүү амьтан чинь Цоодол гуай руугаа “Их баярлалаа, Тандаа” гэж хэлэх гээд утсаа шүүрэн аваад залгатал, барагтай л бол утсаа сонсдоггүй ахын дуу хүнгэнэн-намилзан орж ирээд юу юугүй л “Аа, байна-аа-аа? гэх нь тэр, тэгтэл нь ч муу солиот чинь өөрийн эрхгүй асгаруулж орхисон юм. “Та чинь хүмүүст ямар их хайртай юм бэ!?” гээд үгийн солиогүй цурхирч гарсныг маань эрхэм ах одоо санадаг л байлгүй. “За байз уу, ямар юмыг нь уншаад тэгтлээ их усан нүдэллээ дээ?” гэсхийн бодоод, “одоо нэг эргэж уншсу” гээд хэчнээн эрэвч эргээд тэр олон сайхан дотор нь төөрчхөөд, “Аа тийм, яг энэ ш дээ” гээд дуу алдчихаж

чаддаггүй юм, муу барам чинь. Тийм л олон арван сайхан алтан, мөнгөн баавар урласан гайхалтай уран хийцтэй инжаан юм чинь аргагүй шүү дээ. Нутгийнхаа харчуул, хүүхэн, өвгөд, хөгшдийг бурхан лугаа адил зүйрлүүлэн бичдэг ийм л агуу сэтгэлтэй хүнийг молхи би өнөөх муу “Хүмүүсийн тухай роман”-даа оруулчих гэж хэчнээн санадаг боловч, бүрэн нээж чадахгүй байх гэдгээсээ айгаад, өнөөг хүртэл зүрхлээгүй суунам. Цоодол ахын тэр хөрөг, дурсамжууд ямар гээчийн уран, үгийн сонголт нь ямар гээчийн сонин содон, гайхалтай цэцэн мэргэн зүйрлэлтэй хүүрнэлүүд гэж бодно! “Аргай хэмээх тэр нэгэн муна шиг улаан эр...”, “Гээсэн бөгж шөнө олдмоор тэгш сайхан тал хөндийнүүд минь...”, “Талын булаг жаахаан, жирмэн урсгалтай...”, “Туулай шиг хярсан хэдэн гэр...”, “Тэртээ доор хоёр Төхөмийн нуур хоёр мөнгөн төгрөг шиг цагаарч, сумын жаахан төв борлойно” гэх мэтээр. Үг бүрээс нь хайр үнэртэнэ. “Борлойгоод байхдаа ч яахав дээ” хэмээн голмоор санагдавч, барилга тавилгаар тааруу, гэрүүд нь гэхэд хөдөлмөр өдрийн өчүүхэн хөлсөө жилдээ цөөхөн авдгаас муу бор гэрээ ч цагаан бүрээсээр хулдаж чаддаггүй байсан 1960-аад оны нэгдлийн гэрүүд нүднээ үзэгдэж, нулимс бүрэлзэнэ. Дурсамж гэдэг бол сайтар товчилсон богино үгүүллэг гэсэн үг. Шалгуур нь дөрөвхөн байх ёстой гэдэг. Ердөө дөрөвхөн шүү! Нэгд богино байх ёстой, хоёрт уран бичлэгтэй байх ёстой, гуравт зохиомж нь уран байх ёстой, дөрөвт үйл явдал нь уран байх ёстой. Бүр, “аазгай хөдөлгөм шүү. Энэхэн дөрвөөр л үгүүллэг гээч юм маань хүүрнэл зохиолын хаан болдог. Чеховынх шиг. Чеховын “зурдаг” шиг. Цоодол абугай хөрөг дурсамждаа энэ дөрвийг бол багтааж чаддаг уран бүтээлч бөлгөө” (2021: 10-12) гэжээ.

Харин шүүмжлэгч Ч.Билигсайхан “Д.Цоодол нүүдэлчин сэтгэлгээний дууч юм. Шүлэг, хүүрнэл юу ч бичсэн нүүдэлчин монгол сэтгэлгээ түүнээс тод харагддаг. Жаахан наагуур хэлбэл аргагүй хөдөөний зохиолч, хөдөөний сэтгэлгээ хүн. Д.Цоодол энэ хөдөөний нүүдэлчин сэтгэлгээнд ямар нэг дуураймал, суралцсан юм огт байхгүй. Ер нь сэтгэлгээнд суралцах гэж байдаггүй биз ээ. Тэр дундаа нүүдэлчин сэтгэлгээ гэдэг тэр хүнтэй хамт төрж тэгээд хамт жаргадаг бололтой. Ф.Куперийн хэлсэнчлэн сүүлчийн могиан гэдэг хэллэг энэ удаа миний хувьд Цоодолд хамаатуулж тэр Монголын нүүдэлчин амьдрал, нүүдэлчин сэтгэлгээ XXI зуунд бидний нүдэн дээр төгсөж байх шив дээ. Төв суурин тойрсон энэ хэдэн малчин бараг хагас суурьшлынх юм даа. Та бүхэн өнөөгийн малчдын хэлж, ярьж байгааг анхааралтай сонсоод үзээрэй. Хотынхоос ялгарах юм бараг алга. Хаа ч давтагдашгүй нүүдэлчний амьдралын хэвшил, заншил Цоодолын үзгэн доороос гарсан бүхнээс салхилж байдаг юм. Түүний төрсөн нутаг Бүрэнгийнхэн тэр л намхан хөх уулс, гүндүүгүй эгэл боргил хөдөөгийн түүний бичсэн болгоноос үнэртдэг. Аргагүй л хөдөөний нүүдэлчин зохиолч гэж түүнийг хэлэх байх. Юуны ч тухай бичлээ гэсэн нүүдэлчин малчин хүний сэтгэлээс л үг бүхэн нь амилдаг гэлтэй юм” (2009) хэмээн тэмдэглэсэн байна.

Судлаач болон зохиолчдын түүний уран бүтээлийг үнэлсэн үнэлэлтүүдийг нэгтгэн үзвэл: түүний сэтгүүл зүй болоод орчуулгын ажлууд нь хүүрнэл

зохиол бичихэд нь дөхөм зам болсон байх бөгөөд тэр бээр дурсамж хэлбэрээр зохиол бүтээлээ хүүрнэн өгүүлж, төрсөн нутгийнхаа зон олны ахуй амьдралыг тод томруун дүрсэлж, монгол хүний нинж сэтгэлийг дэлгэн үзүүлдэг онцлог шинжүүд харагдаж байна.

Д.Цоодолын бүтээл амилах орчин

“Миний бичээд, бичээд дуусдаггүй Бүрэн минь” Д.Цоодол

“Уран зохиолд орон зай ямар нэгэн хэмжээгээр дүрслэгддэг бөгөөд мөнхүү орон зайн дүрслэл нь нүүдэлчдийн урлаг, уран зохиолд нэн чухал үүрэгтэйгээр дүрслэгддэг онцлог байна. Суурь гурван урлагт буюу уран зохиол, уран зураг, хөгжимд агуулгыг хэрхэн илэрхийлж байгааг нь нээн тайлбарлах нэгэн чухал ойлголт нь орон зай, цаг хугацааны дүрслэл байдаг. Уран зохиол дахь орон зай, цаг хугацааны асуудлыг Оросын судлаач, философич М.Бахтин тусгайлан судалж хронотоп хэмээн томъёолсон бий. Нүүдэлчдийн урлагт орон зай илүүтэй дүрслэгддэг онцлогтой” (Батсуурь, 2022: 81).

Уран зохиолын дүрслэгдэхүүний талаар ярихад тэрхүү хүн-тусагдахуун хаана, хэдийд оршин тогтнох вэ? гэдэг асуултад хариулт өгөх хэрэг гардаг. Тиймээс зохиолын хэрэг явдал болж буй орон зайн болоод цаг хугацааны хамаарал бүхий ойлголтыг судлах хронотоп судлал бий болжээ. Бидний судлан буй зохиолчийн зохиол бүтээлийн орон зай буюу орчин нь бодит орон зай гэж хэлж болно. Тухайлбал, Бүрэнгийн ухаа толгод, нутгийн зон олон бол Дөнгөтийн Цоодолын бүтээл амилах орчин юм. Түүний эх нутаг, газар шороо, хүний өөрийн ах дүүсээ хайрлан энэрэх, түүх, соёлоо үлдээн өвлүүлэх, ёсорхон хүндэтгэх үзэл санаа олон зохиол бүтээлд нь тусгалаа олсон байдаг.

Ялангуяа хүүрнэл зохиол болоод дуулиудаас нь Бүрэн сумынхны амьдрал, ахуй байдал, хүн ардын жаргал зовлон, хэв заншил тод харагддаг. Тиймээс түүний зохиолууд дахь дүр дүрслэл, ахуй дүр нь зохиолчийн амьдрал ахуйд тохиолдсон явдлаас эх үндэстэй бөгөөд бодит байдлын уран сайханжсан тусгал гэж хэлж болно. Тухайлбал, “Талын булаг”, “Сарваа цуцахын тал”-“Жарангийн хөндий” зэрэг зохиолчийн төрөлх нутгийн газар усны нэр, хүн ардын түүх олонтоо дурдагддаг. Энэ тухайд нь зохиолч, судлаач До.Цэнджав түүний бүтээлээс “Бүрэнгийн үг хэллэг”, “Талынбулгийн үг хэллэг” онцгой содон дурайна” гээд “Өсөж төрсөн Талынбулагийнханы тэрхүү гудиггүй, хэнэггүй ч гэмээр хүмүүсийн амьдрал ахуй, зан араншин, үг яриа домог мэт нэхэл эсээнд шингэжээ” (Цэнджав, 2019) гэсэн бол төр нийгмийн зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Лүндээжанцан “Цоодол ах” хөрөг нийтлэлдээ “Хөдөөгийн өвөлжөө, хаваржааны шар бууцны үнэр ханхалж намрын чимчигнэсэн айраг хамар цоргиж, дал дөрвөн өндөр, адууны хятай идсэн юм шиг санагдсан. Ердөө л Бүрэнгийн урд бие, Сарваа цуцахын тал, Талын булаг, Булгуудын цэц, хойшлоод Бүрэнгийн төв энэ хэсгийн газрын хүн зоны амьдралыг харуулсан өгүүллэгүүд нь хүний дотоод мөн чанар, хүн бүрийн бусдаасаа ялгарах үл давтагдах онцлог шинжийг нээн

харуулж чадсанаараа Бүрэнгийн хонхрын тухай зохиол бус Бүрэнгийн хонхроо дэлхийд гаргасан зохиолч болсныг ухаарлаа” (2016) хэмээн бичсэн байдаг. Түүнчлэн зохиолч Б.Золбаяр, “Хүний сайхан хорвоо, түүний дотор Бүрэнгийн тал хээрээр амьдарсан, амьдран буй сайхан сэтгэлт, зөв ёст элбэр үү ачит сэтгэлт олныхоо далай хайрыг зохиолч маань дуурьсган бадраажээ. Ингэхдээ инээд хөөр, өнөө л цагаахан егөө, амьдралын сонин хачин учрал, дууль, домог бүгдийг багтаасан нь тун тунг нь тааруулж найруулсан гайхам судар болсныг эс хэлж яахин зүрхэлнэ” (2012) гэж бичсэн нь бий.

“Аливаа зохиол бүтээлийг ойлгож, мэдэхийн тулд зохиолчийн намтар, өссөн ахуй орчин, нийгмийн байдлыг анхааран үзэх ёстой”-г Америкийн утга зохиолын онолч Р.Уоллек, О.Уоррен нар “Утга зохиолын онол” бүтээлдээ анх дэвшүүлсэн бөгөөд өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна. Зохиолчдын өсөж төрсөн нутаг, ахуй нь тэдний зохиол бүтээлийн салшгүй хэсэг, амин сүнс нь болж, тэдний оюун бодол дахь хийсвэр ахуйг бүрдүүлж, бодит ахуй болгож цаасанд буухад ихээхэн хөшүүрэг болдог байна. Ямар ч зохиолч уран сайхны дүрийг бүтээж, хийсвэр зохиомол орчныг оюун санаандаа зураглан буулгадаг хэдий ч тэр нь амьдралын үнэнээс урган гарч, уран сайхнаар баяжсан байдаг билээ.

Д.Цоодолын хүүрнэл зохиолын онцлогууд

Д.Цоодол нь хүүрнэл зохиолын төрлөөр “Хонины боол” (2008), “Хөөс” (2011), “Нулимс холоос харагдахгүй” (2013), “Дуулж дуусдаггүй орчлон” (2015), “Талынбулагийн вант улс” (2018), “Ганзагалаа” (2019) зэрэг ном хэвлүүлсэн байна. Эдгээр нь хүүрнэл зохиолын өгүүллэг, эсээ, туурь, нэхэн дурсахуй, ойлбор, дурсамж, ёгтлол, егөөдөл, сэтгүүл зүйн нийтлэл зэрэг олон зүйлд хамаарах юм. Түүний хүүрнэл зохиолын зүйлчлэлийн талаар До.Цэнджав өгүүлэхдээ Д.Цоодол нь “бүтээхүйн урын сандаа жижиг жижиг тэсрэлт үүсгэсэн уран гойд бичил зүйлчлэлийг бий болгохдоо “уран зохиолыг сэтгүүлжүүлж, сэтгүүл зүйг уран зохиолжуулах” шинэчлэл хийжээ гэж үзэж болохоор байна” (2014) хэмээжээ.

Д.Цоодолын хүүрнэл зохиолд дурсамж чухал байр суурьтай бөгөөд түүний хүүрнэх арга барил нь дурсахуй гэж хэлж болно. Дурсамж бол хэрэгтэй цагт нь гаргана даа гэж бодоод авдрын мухар луу шидээд мартсан ямарваа нэгэн эд шиг бодит зүйл биш. Хэзээ ч, хаана ч дахин амилж мэдэх, бидний зүрх сэтгэлийн нойрсож буй ой дурсгал. Мартаж, санахын заагт тээж явдаг тийм нэгэн санах ой. Түүний зохиолууд дурсамж гээч нь зөвхөн өнгөрсөнд хамаатай биш ирээдүйг ч багтаах асар том орон зайд эргэлдэж, хувирч байдаг амьд чанартай.

Д.Цоодолын хүүрнэл зохиолын бусдаас ялгарах ур чадвар, онцлог шинж нь амьд ахуйлаг орчин, амьд хүүрнэл, амьд дүр, амьд үг хэллэг, амьд хөдөлгөөн, амьд барим тавим үйл юм. Түүний зохиолуудыг уншиж байхад барагтай бол хүний нүдэнд өртөхөөргүй нуугдмал зүйлийг нээж хэн бүхэн олж харах аргагүй ер бусын шинжийг нь олж бичдэг байна. Ялангуяа эсээнийх нь номыг уншиж

байхад жирийн амьдрал дотроос ер бусын шинж чанартай зүйлийг ялган олж бичих гэдэг сониуч гэмээр зан нь тодхон харагдана.

Түүний хүүрнэл зохиолуудын сэдэв бол монгол нутаг, хөдөө тал, хөдсөн дээлт хөх өвгөд, мал сүрэг, малчин ард юм. Мөн монгол хүний мөс жудаг, мөн чанар, нинж сэтгэл юм. Өөрөөр хэлбэл, нүүдэлчдийн сэтгэлгээг эх хэлээр нь дамжуулан уран дүрслэл бүтээж зохиолынхоо санааг нээдэг уран бүтээлч бол Д.Цоодол юм.

“Нулимс холоос харагдахгүй”, “Зугаатай өдөр”, “Угаасан эсгий малгай”, “Навтарга” гээд л бараг бүх зохиолоос нь монгол хүний үнэнч шударгуу чигч шулуун зан, энэрэл хайр, эх нутаг, элгэн саднаа гэсэн мах цусанд шингэсэн уугуул бодол сэтгэл, бэрхшээлийн өмнө сөхөрч сөгддөггүй ясны хатуу чанар, монгол хүний холч, голч ухаан харагддаг. Түүнийхээ хажуугаар амьдралыг шорвог гашуун болгож буй бусармаг явдал, буруу тэрслүү хүмүүсийн үг үйлдлийг ч уншигчдад эгдүүцэл, зэвүүцэл төрүүлэхээр дүрслэн бичсэн байдаг. Үйл явдлын олон зөрчил бий болгох гэхээсээ илүү тухайн хүний мэдрэмж рүү хандсан, үг бүрээр нь уншиж байж ойлгох, мэдрэх шинж Д.Цоодолын хүүрнэл зохиолуудад агуулагдсан байдаг.

Зохиолчийн хүүрнэл зохиолын дүрслэлүүд нь нэн өвөрмөц нарийн чимхлүүр байдаг. Тэр бээр зохиолууддаа ямар нэгэн жижиг зүйл (эд юмс, хөндлөнгийн хүн, мал амьтан, ургамал гэх мэт)-ийг дүрсэлдэг бөгөөд тэрхүү жижиг зүйлийн дүрслэлээр зохиолынхоо дүрүүдийн дотоод сэтгэлийг нээдэг онцлогтой. Тодруулбал, “Хонгор Намнан” өгүүллэгт: “Тэрийн баруун хаяанаас сойсон аарцны хүүдийнээс шар сүү хаяа нэг дуслах, хоймрын авдар дээрх хөлтэй орос цаг түг түг цохилохоос өөр чимээ аниргүй. Хаяагаар орох салхиар агь, саяхны бороонд сэргэсэн ногооны үнэр сулхан ханхалж, үл мэдэг сэрүү татах нь аятайхан. Тооноор харан хэвтэхэд тэртээ дээр хөх тэнгэр, өнгө өнгийн үүл нэг л мэдэхэд байрандаа үгүй болж, оронд нь бас нэгэн үүл гараад ирчихсэн байна. Эсвэл тэнгэр улам хол, улам хөх өнгөтэй болж, тэнд нэгэн бараан шувуу элэн халин эргэлдэн ниснэ” (Цоодол, 2015: 265) гэхчлэн дүрслэн бичжээ. Иймэрхүү чимхлүүр дүрслэлээр зохиолч баатруудынхаа дотоод сэтгэлийг илэрхийлдэг онцлогтой. Энэ мэт жишээ олныг дурдаж болно.

Түүнчлэн түүний хүүрнэл зохиолууд бүхэлдээ егөөдөл, паян, инээд наргиа, дүрсгүйтэл, хөгтэй явдал, хошигнолоор дүүрэн байдаг онцлогтой. Энэ нь түүний зохиолуудыг амь оруулан хөдөлгөөнд оруулдаг өвөрмөц онцлог нь юм.

Дүгнэлт

Д.Цоодол нь өөрийн гэсэн туурвил зүйн арга барил, өвийг бүтээсэн монголын орчин үеийн уран зохиолын томоохон төлөөлөгч билээ.

Түүний сэтгүүл зүй болоод орчуулгын ажлууд нь хүүрнэл зохиол бичихэд нь дөхөм зам болсон байх бөгөөд тэр бээр дурсамж хэлбэрээр зохиол бүтээлээ хүүрнэн өгүүлж, төрсөн нутгийнхаа зон олны ахуй амьдралыг тод томруун

дүрсэлж, монгол хүний нинж сэтгэлийг дэлгэн үзүүлдэг онцлог шинжүүд харагдаж байна.

Хүүрнэл зохиол болоод дуулиудаас нь Бүрэн сумынхны амьдрал, ахуй байдал, хүн ардын жаргал зовлон, хэв заншил тод харагддаг. Д.Цоодолын хүүрнэл зохиолд дурсамж чухал байр суурьтай бөгөөд түүний хүүрнэх арга барил нь дурсахуй гэж хэлж болно.

Abstract:

The article deals with the features of the narrative writings of D. Tsoodol, the State Honored Writer of Mongolia and Honored Worker of Culture. In doing so, the author aims to highlight the distinctive skills and characteristics of D. Tsoodol's narrative writings. The author also considered the environment in which D. Tsoodol's works came to life and writes about his narrative style. D. Tsoodol is a major representative of modern Mongolian literature who has created his own creative style and legacy.

His journalism and translation work must have been a favorable path for him to write narrative writing, and he narrates his works in the form of memoirs, vividly portrays the daily life of the people of his native land, and reveals the characteristics of the Mongols.

The lifestyle, circumstances, joy, pain and morals of the people of Buren soum are clearly visible in his narrative writings and ballads. Memory plays an important role in D. Tsoodol's narrative writings, and his narrative style can be said to be memorial.

Ном зүй

- Батсуурь, Г.** (2022). Зохиолч Ж.Лхагвагийн өгүүллэгийн хэл найруулга, дүрслэлийн онцлог. “XX зууны монгол өгүүллэгийн үнэт зүйл-Ж.Лхагва” эмхэтгэл. 76-83 дугаар тал. Улаанбаатар: “Жиком пресс” ХХК. 132 х. [Batsuuri, G. Zohiolch J. Lhagvagiin uguullegiin khel nairuulga, dursleliin ontslog. [Features of the language, composition and imagery of the story by writer J. Lkhagva]. Ulaanbaatar: Gcom press. 2022]
- Билигсайхан, Ч.** (2009). Монгол найргийн тамгатай түшээ. Улаанбаатар: “Өдрийн сонин”. №031. [Biligsai Khan, Ch. Mongol nairgiin tamgatai tushee. [A staff with the stamp of Mongolian poetry]. Ulaanbaatar: Daily newspaper. 2009]
- Золбаяр, Б.** (2012). Тал нутгийн намуухан аялгуу бүүвэйлэмтгий шүү. “Хүмүүн” хөрөг тэмдэглэл. Улаанбаатар: “Мөнхийн үсэг”. [Zolbayar, B. Tal nutgiin namuuhан ayalguu buuveilemtgii shuu. “Humuun”. [The soft melody of the steppe is enchanting. “Human”]. Ulaanbaatar: Monkhiin Vseg press. 2012]
- Лүндээжанцан Д.** (2016). Цоодол ах. Улаанбаатар: [Lundeejantsan, D. Tsoodol akh. [Brother Tsoodol]. Улаанбаатар] <https://itoim.mn/article/%D1%86%D0%BE%D0%BE%D0%B4%D0%BE%D0%BB/4009>

- Нэргүй, Ж.** (2021). *Юуны учир Цоодол абугай орчуулга хийдэг вэ*. Д.Цоодолын орчуулсан Альфонс Доде “Алтан тархит хүмүүний домог” номын өмнөх үг. Улаанбаатар: “Сэлэнгэ” пресс. 10-12 дугаар тал. 229 х. [Nergui, J. *Yunii uchir Tsoodol abugai orchuulga khiideg ve*. [Why does Tsoodol translate?]. Alphonse Daudet “The Man with the Golden Brain” translated by D.Tsoodol]. Ulaanbaatar. Selenge press. 2021]
- Пүрэв, С.** (2013). *Миний улаачлан баясахын учир*. Д.Цоодолын “Нулимс холоос харагдахгүй” номын өмнөх үг. Улаанбаатар: “Сэлэнгэ пресс” ХХК. 3-4 дүгээр тал. 370 х. [Purev, S. *Minii ulaachlan bayasahin uchir. D.Tsoodol “Nulims kholoos kharagdakh guii”*. [The reason for my blushing joy. D.Tsoodol “Tears are not visible from afar”]. Ulaanbaatar: Selenge press. 2013]
- Пүрэвсүрэн, П.** (2011). *Хуучин андын шинэ ном уншаад хүүхэд болтлоо баярлах...* Д.Цоодолын “Хөөө” номын өмнөх үг. Улаанбаатар: “Сэлэнгэ пресс” ХХК. 3-4 дүгээр тал. 394 х. [Purevsuren, P. *Khuuchin andiin shine nom unshaad khuukhed boltloo bayarlakh*. D.Tsoodol “Khöyeö”. [I'm as happy as a child when I read an old friend's new book... D. Tsoodol “Khöyeö”]. Ulaanbaatar: Selenge press. 2011]
- Цоодол, Д.** (2008). *Хонины боол*. Улаанбаатар: “Жиком пресс” ХХК. 236 х. [Tsoodol, D. *Khoninii bool*. [D.Tsoodol “Slave of the sheep”]. Ulaanbaatar: Gcom press. 2008]
- Цоодол Д.** (2015). *Дуулж дуусдаггүй орчлон*. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК. 538 х. [Tsoodol, D. *Duulj duusdaggui orchlon*. [D.Tsoodol “The never-ending universe”]. Ulaanbaatar: “Monkhiin Vseg” press. 2015]
- Цоодол Д.** (2018). *Талынбулагийн вант улс*. “Сэлэнгэ пресс” ХХК. Уб., 306 х. [Tsoodol, D. *Taliinbulagiin vant uls*. [D.Tsoodol “Talynbulag Kingdom”]. Ulaanbaatar: “Selenge press” press. 2018]
- Цэнджав Д.** (2019). *“Ганзагалаанд” зангидах ганзага үгс*. Д.Цоодол “Ганзагалаа”. Улаанбаатар: 7-11 дүгээр тал., 306 х.[Tsendjav, D. “*Ganzagalgaand” zangidakh ganzaga ugs*. [“Ganzagalgaand” is a collection of words that are tied together. Ulaanbaatar: 2019]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.